



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/39


Улаанбаатар хот

Судалгаа шинжилгээний ажлын арга зүйн сургалт семинар зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2017 оны 289 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтнуудад зориулсан судалгаа шинжилгээний ажлын арга зүйн сургалт семинарыг 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсугай.
2. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах 590.000 /Таван зуун ерэн мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Сургалт семинарын урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА




Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны *11 дугаар* сарын *16*-ны өдрийн
А/59 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Судалгаа шинжилгээний ажлын арга
зүй сургалт семинар зохион
байгуулах тухай төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын зардал: 1 хоног х 6 цаг 50.000 төг = 300.000 төг	300.000
2.	Заал талбайн зардал	200.000
3.	Бичиг хэрэг, цай кофе	90.000
Нийт дүн		590.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны...*11 дугаар*... сарын *16*-ны өдрийн
А.59. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Судалгаа шинжилгээний ажлын арга
зүй сургалт семинарт хичээл заах багш
нарын бүрэлдэхүүн

- | | |
|--------------------------------|--------------|
| 1. ННБТСХорооны хэлтсийн дарга | А.Болдмаа |
| 2. ЗГХА БТСГазрын мэргэжилтэн | Ш.Долгор |
| 3. ҮБТДС-ийн захирал | Л.Алтанцэцэг |
| 4. “Аварга” БТДС-ийн зөвлөх | А.Сүхбат |